



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/250

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуулийн 4.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих "10 алхам"-ыг хэрэгжүүлэх зааврыг хавсралтаар баталсугай.
2. Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих "10 алхам"-ыг хэрэгжүүлэн ажиллахыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нарт даалгасугай.
3. Уг зааврыг эрүүл мэндийн байгууллагуудад танилцуулах, хэрэгжилтийг хангах, сургалт, сурталчилгаа зохион байгуулах, хамтрагч талуудад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв /Д.Нарантуяа/-д даалгасугай.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн газар /Т.Энхзаяа/-т үүрэг болгосугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

081094

Эрүүл мэндийн сайдын
2019 оны 06 сарын 13... өдрийн
#1290 дугаар тушаалын хавсралт

ЭХИЙН СҮҮГЭЭР ХООЛЛОЛТЫГ ДЭМЖИХ "АРВАН АЛХАМ"-ЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗААВАР

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Дэлхийн эрдэмтдийн судалгаа, нотолгооны үр дүнд үндэслэн, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ), Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн Сан (НҮБ-ын ХС), Хүүхдийг Эхийн Сүүгээр Хооллох Дэлхийн Холбоо зэрэг олон улсын байгууллага, Дэлхийн олон орны Засгийн газар, эмч нар, сайн дурынхны санаачлагаар хүүхдийг эхийн сүүгээр хооллох уламжлалыг сэргээх өргөн цар хүрээтэй ажлыг 1990-ээд оноос эхлүүлсэн түүхтэй.

Хүүхдийг эхийн сүүгээр хооллоход нярайн эндэх тохиолдлыг 33 хувиар, эх хөхний хавдраар өвдөх эрсдэлийг жил бүр 6 хувиар бууруулах ба хөхний хавдраас шалтгаалсан 20 000 нас баралтаас сэргийлнэ. Мөн нэг жилд дэлхийн эдийн засгийг 300 тэрбум доллараар хэмнэнэ гэсэн тооцоог ДЭМБ-аас гаргасан байна.

ДЭМБ-ын удаа дараагийн чуулга уулзалтуудаас хүүхдийг эхийн сүүгээр хооллох, дэмжих, хамгаалах, амаржих газар, төрөх тасаг болон эх, хүүхдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагууд "Хүүхдэд ээлтэй эмнэлэг" ("ХЭЭ") болох санаачлагыг хэрэгжүүлэх талаар олон шийдвэр гаргасан. Үүнд:

1990 оны 43-р чуулганаас: Эхийн сүүгээр хооллолтыг сурталчлах, хамгаалах, хүүхдийн амьдралын эхний 4-6 сард эхийн сүүгээр дагнан хооллох, хянах, ажил эрхэлж буй хөхүүл хүүхэдтэй эхчүүдийг дэмжих;

2002 оны 55-р чуулганаас: Нялх, бага насны хүүхдийн хооллолтыг дэмжих Дэлхийн стратегийг баталсан ба тус стратегид "Эхийн сүү нь хүүхдийн бие махбодын хэвийн өсөлт, хөгжилтийг хангахад зориулагдсан төгс найрлагатай, орлуулашгүй хүнс болохоос гадна эхийн нөхөн үржихүйн үйл ажиллагааны салшгүй хэсэг мөн" гэж тодорхойлсон.

2010 оны 63-р чуулганаас: Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих, сурталчилах, хамгаалах, "ХЭЭ" болох санаачлагыг амаржих газар, төрөх тасгууд үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх;

2018 оны 71-р чуулганаас: Улс орнууд "ХЭЭ" болох санаачлагыг дахин сэргээх, амаржих газар, төрөх тасаг болон эх, хүүхдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагууд хүүхдийг эхийн сүүгээр хооллолтыг дэмжих "Арван алхам"-ын шинэчилсэн зааврыг хэрэгжүүлэхийг зөвлөмж болгосон.

Монгол улс 1992 оноос эхлэн ДЭМБ, НҮБ-ын ХС-гийн дэмжлэгтэйгээр хүүхдийг эхийн сүүгээр хооллох бодлогыг үндэсний түвшинд хэрэгжүүлж "ангир уураг"-аар төрсний дараах эхний 1 цагийн дотор амлуулах, хүүхдийг амьдралын эхний саруудад эхийн сүүгээр дагнан хооллох, эх хүүхдийг арьс, арьсаар шүргэлцүүлэх замаар тэдний холбоог бэхжүүлэх, хүүхдийг хүссэн үед нь хөхүүлэх, эхчүүдийг хүүхдээ хөхүүлэхэд нь эмч, эх баригч нар тусламж дэмжлэг үзүүлж, хөхүүлэх арга барилыг зааж сургах зэрэг дадлуудыг нэвтрүүлсэн юм.

Монгол Улсын хэмжээнд 1992-2007 онд хот хөдөөгийн нийт 192 эмнэлэг “ Хүүхдэд ээлтэй эмнэлэг” цол гэрчилгээ авч Ховд, Дорноговь, Завхан зэрэг аймгийн нэгдсэн эмнэлэг, бүх сумын эмнэлэг нь “Хүүхдэд ээлтэй эмнэлэг” болсноор “Хүүхдэд ээлтэй аймаг” болж байсан туршлагатай. Гэвч 2011 оноос эхлэн “Хүүхдэд ээлтэй эмнэлэг” болох санаачлага зогсонги байдалд орсноор хүүхдийг эхийн сүүгээр хооллох үзүүлэлт жилээс жилд буурсан байна. Тухайлбал: 2010 онд нийт нялхсын 85.5 хувь нь төрөөд нэг цагийн дотор ангир уургаа амласан, 66 хувь нь төрснөөс хойш эхний 6 сарын турш зөвхөн эхийн сүүгээр дагнан хооллож, хоёр нас хүртлээ эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллож буй хүүхэд 73.1 хувь байсан бол 2017 онд нялхсын 83.7 хувь төрөөд нэг цагийн дотор ангир уургаа амласан, зургаа хүртэлх сартай хүүхдийн 58.3 хувь эхийн сүүгээр дагнан хооллож байна. Хоёр нас хүртлээ эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллож байгаа хүүхэд 47.3 хувь болж буурсан байна.

Иймд амаржих газар, төрөх тасаг болон эх, хүүхдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагуудад Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих 10 алхамыг хэрэгжүүлэх зааврыг шинэчлэн боловсруулав.

ХОЁР. ЗОРИЛГО:

Эх, хүүхдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын үйл ажиллагаанд эхийн сүүгээр хооллолтыг дэмжих “Арван алхам”-ыг нэвтрүүлэхэд энэхүү зааврын зорилго оршино.

ГУРАВ. ЭХИЙН СҮҮГЭЭР ХООЛЛОЛТЫН ҮНДСЭН ОЙЛГОЛТ:

ДЭМБ болон НҮБ-ын Хүүхдийн сан улс орнуудад дараах зөвлөмжүүдийг өгсөн. Үүнд:

- Хүүхдийг төрмөгц нэг цагийн дотор ангир уургийг амлуулах.
- Амьдралын эхний зургаан сард эхийн сүүгээр дагнан хооллох.
- Хүүхдийг зургаан сар хүрмэгц эхийн сүүгээр хооллохын зэрэгцээгээр аюулгүй, насанд нь тохирсон нэмэгдэл хоолоор хооллох ба хоёр нас хүртэл нь, боломжтой бол түүнээс дээш эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллох.

Ангир уураг: Төрсний дараах цөөхөн хэд хоногт маш бага хэмжээ (эхний 24 цагт 24-30мл)-тэй ялгардаг өвөрмөц найрлагатай тод шаргал сүүг ангир уураг гэж нэрлэдэг.

Онцлог чанар	Ач холбогдол
Эсрэг биеэр баялаг	Харшил болон халдвараас хамгаална.
Цагаан эс ихтэй	Халдвараас хамгаална.
Цэвэрлэх үйлчилгээтэй	Зунгагийг түргэн гадагшлуулж, хүүхдийн гэдсийг цэвэрлэнэ. Төрсний дараах шарлалтаас сэргийлнэ.
Өсөлтийн хүчин зүйлс болдог	Хүүхдийн гэдэс хөгжихөд тусална. Харшил үүсэх, хоол хүнс тохирохгүй болохоос сэргийлнэ.
А аминдэмээр баялаг	Халдварын хүндрэлийг бууруулна.

- Ангир уураг нь эсрэг бие болон халдварын эсрэг уургыг найрлага тогтмолжсон сүүнээс илүү их хэмжээгээр агуулдаг.
- Найрлага нь тогтмолжсон сүүнээс илүү их хэмжээтэй цагаан эс агуулдаг.
- Шинэ төрсөн нярайг нянгийн халдвараас сэргийлдэг бөгөөд төрсний дараа хүүхдэд тохиолдож болох олон өвчний эсрэг анхны дархлааг үүсгэдэг.

- Ангир уураг нь бага зэргийн туулгах үйлчилгээтэй тул хүүхдийн гэдсийг зунгаг (анхны бараан өнгөтэй баас)-аас цэвэрлэж өгдөг. Ийнхүү билирубиныг биеэс зайлуулан цэвэрлэснээр нярайн шарлалт, түүний хүндрэлээс сэргийлнэ.
- Ангир уураг нь өсөлтийн хүчин зүйлс агуулдаг тул хүүхдийн гэдэс гүйцэд хөгжихөд эерэгээр нөлөөлж бусад төрлийн хоол, хүнс тохирохгүй болох, харшил үүсэхээс сэргийлж чадна.
- Ангир уураг нь А аминдэмээр баялаг тул хүүхдэд тохиолдож болох аливаа халдварын хүндрэлийг бууруулахад нөлөөлнө.

Эхийн сүүгээр дагнан хооллох гэдэг нь хүүхдэд ямар нэг хоол болон шингэн зүйл, ус ч өгөхгүйгээр зөвхөн эхийн сүүгээр хооллохыг хэлнэ. Хүүхдэд аминдэм, эрдэс бодис агуулсан дусаалга, сироп болон эмийн бэлдмэл өгөхдөө амархан залгиулах зорилгоор ус өгч болно.

Эхийн сүүний ач холбогдол:

- Түргэн боловсорч, хүүхдийн биед бүрэн шимэгддэг.
- Зургаа хүртэлх сартай хүүхдийн үндсэн шимт бодис болон аминдэм, эрдэс, шингэний хэрэгцээг бүрэн хангана.
- Үргэлж цэвэр, бэлэн байх бөгөөд температур нь тохирсон хэмтэй байна.
- Өвчний эсрэг, ялангуяа суулгалт, амьсгалын замын халдвараас хамгаалах эсрэг бие агуулдаг.

Эхийн сүүгээр хооллолтын ач холбогдол:

- Нялх хүүхдийн амь насыг аварна.
- Өсөлт, хөгжилтийг дэмжиж, өсөлт хоцролтоос сэргийлнэ.
- Хүүхдийг халдвараас хамгаална.
- Хүүхдийн ам, тагнай, эрүү хацрын булчингийн хөгжил сайжирснаар хүүхдийн шүд зөв ургаж, хожим хэл ярианы хөгжилд сайнаар нөлөөлдөг.
- Эх, хүүхдэд хайр, энхрийлэл, дотно харилцааг бэхжүүлснээр хүүхдийн хүмүүжилд эерэгээр нөлөөлнө.
- Хүүхдийн оюун ухааны хөгжлийг дэмжиж, IQ чансааг 3-4 оноогоор дээшлүүлдэг.
- Хүүхэд бага уйлдаг ба илүү тайван байна.
- Хожим таргалалт, чихрийн шижингээр өвчлөх эрсдэлийг бууруулна.

Эхийн сүүгээр хооллолтын эхэд үзүүлэх ач холбогдол:

- Амаржсаны дараа хүүхдийг нэн даруй амлуулбал:
 - Эхэс түргэн ховхорно. Учир нь хүүхэд хөхөө хөхөх үед умайн агшилт сайжирдаг байна.
 - Төрсний дараа цус алдах эрсдэлийг бууруулна.
 - Эхийн хөхөнд сүү боловсролт эрчимжинэ.
- Зургаан сар хүртэлх насны хүүхэдтэй, сарын тэмдэг нь ирээгүй байгаа эх хүүхдээ эхийн сүүгээр дагнан хооллосноор жирэмслэлтээс 98% үр дүнтэй хамгаалж чадна.
- Эх, үрийн холбоог сайжруулна.
- Эхийн ажлыг хөнгөвчлөнө. Хүүхдийн сүүн тэжээл худалдан авахаар дэлгүүр явах, ус буцалгах, мод, түлш бэлтгэх, сүүн тэжээл бэлтгэхэд цаг зарцуулахгүй.
- Өндгөвч, хөхний хавдраар өвчлөх, яс сийрэгжих эрсдэлийг бууруулна.

Эхийн сүүгээр хооллолтын гэр бүлд үзүүлэх ач холбогдол:

- Эх хүүхэд эрүүл байна.
- Төрөлт хоорондын зайг уртасгана.
- Эхийн сүүгээр хооллолт нь эдийн засгийн хувьд хэмнэлттэй. Хүүхдийн сүүн тэжээл нь өндөр үнэтэй, эхийн сүүгээр хооллоогүй эсвэл холимог хооллолттой хүүхэд өвчлөмтгий байдаг тул эмчилгээ, үйлчилгээний зардал гарна.
- Хүүхдийн сүүн тэжээл, малын сүүний хэрэглээнээс шалтгаалсан өвчнийг эмчлэхэд гарах эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардлыг хэмнэнэ.

Эхийн сүүгээр хооллолтын олон нийт/ үндэстэнд үзүүлэх ач холбогдол:

- Эрүүл хүүхэд нь эрүүл үндэстэнг бий болгоно.
- Хүүхдийн өвчлөл буурч, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардал багасч, төсөвт хэмнэлт гаргана.
- Хүүхдийн өвчлөл, нас баралтыг бууруулж, улмаар хүүхдийн эсэн мэнд амьдрах чадвар сайжирна.
- Байгаль орчныг хамгаална. Хүүхдийн сүүн тэжээл, хоолны хэрэгслийг цэвэрлэх, ус буцалгахад мод түлээ ашиглахгүй ба сүүн тэжээлийн сав баглаа боодлын хог хаягдал гарахгүй.
- Сүүн тэжээл эсвэл малын сүүг бэлтгэхэд шаардлагатай сав суулгыг импортоор авахгүй. Иймээс түүнд зарцуулах мөнгө хэмнэгдэж, өөр зүйлд ашиглах боломжтой болно.

ДӨРӨВ. ЭХИЙН СҮҮГЭЭР ХООЛЛОЛТЫГ ДЭМЖИХ “АРВАН АЛХАМ”

1. Эхийн сүүгээр хооллох бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр өөрийн байгууллагын үйл ажиллагааны үндсэн зарчмыг тодорхойлж, удирдамж болон төлөвлөгөөг боловсруулж баталсан байх.
2. Зайлшгүй эзэмшвэл зохих онол болон дадлын хангалттай мэдлэг, ур чадварыг байгууллагын ажилтнуудад олгож, сургасан байх.
3. Жирэмсэн эмэгтэйг хүүхдээ эхийн сүүгээрээ хооллоход бэлтгэх, тэдэнд эхийн сүү болон хүүхдээ хөхүүлэхийн ач тусыг ойлгуулах (гэр бүлийн хамт).
4. Эрүүл мэндийн байгууллагууд төрсний дараах эхний 90 минутад эх, нярайд эхийн сүүгээр хооллох тусламжийг үзүүлэх.
5. Эхчүүдэд хүүхдээ хөхүүлэх, саах аргыг сургасан байх ба нийтлэг тохиолддог бэрхшээлийг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх.
6. Хүүхдийн сүүн тэжээлээр хооллож буй (эх нь хүндээр өвдсөн, ХДХВ-ийн халдвартай, нас барсан г.м) хүүхэдтэй асран хамгаалагч нарт тусламж дэмжлэг үзүүлэх.
7. Төрсний дараа эх, хүүхдийг ямагт хамт нэг өрөөнд байлгана.
8. Хүүхдийг хүссэн үед нь хөхүүлэх
9. Угж болон саатуулах хөхөлт хэрэглэхийн сөрөг үр дагаврын талаар зөвлөгөө өгөх
10. Төрөх эмнэлгээс гарсны дараа ч эх, хүүхдэд үргэлжлүүлэн дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.

4.1 НЭГДҮГЭЭР АЛХАМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗААВАР:

Эхийн сүүгээр хооллох бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн өөрийн байгууллагын үйл ажиллагааны үндсэн зарчмыг тодорхойлсон байх

1. Эрүүл мэндийн байгууллагууд нь өөрийн онцлогтоо тохируулан эхийн сүүгээр хооллолтыг дэмжих “Арван алхам” -ын 8-аас дээш үйл ажиллагааг бодлого, төлөвлөгөөндөө тусгасан байна.
2. Хүүхдийн сүүн тэжээл болон угжаар хооллох тухай зөвлөмж заавар, түүнийг дэмжсэн үйл ажиллагааг хориглосон, хүүхдийг насанд нь тохируулан эхийн сүүгээр хооллох хатуу бодлоготой байх ба энэхүү бодлогод дараах хууль эрх зүйн болон бодлогын бичиг баримтуудын зүйл, заалтуудыг тусгасан байна. Үүнд:
 - Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого
 - Нялх, балчир насны хүүхдийн хүнсний тухай хууль
 - “Хүн амын хоол тэжээл” -ийн үндэсний хөтөлбөр
 - Нялх, балчир хүүхдийг хооллох заавар
3. Хүүхдийг эхийн сүүгээр хооллох бодлогыг хэрэгжүүлэхэд байгууллагын эмч, ажилчдын оролцоог тодорхойлсон, хэрэгжүүлэх боломжоор хангана.
4. Хэрэгжилтийн үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлттэй байна.
 - Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих бодлого, удирдамж, төлөвлөгөө
 - Байгууллагын ажилчдыг сургалтанд хамруулсан байдал
 - “Арван алхам” -ын үйл ажиллагааны хэрэгжилтийн байдал
 - Жирэмсэн эмэгтэйчүүд, хөхүүл эхчүүдийг сургалтанд хамруулсан байдал
 - Эзэмшвэл зохих дадлууд

4.2 ХОЁРДУГААР АЛХАМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗААВАР:

Зайлшгүй эзэмшвэл зохих онол болон дадлын хангалттай мэдлэг, ур чадварыг байгууллагын ажилтнуудад олгож, сургасан байх

1. Байгууллагын ажилчдад зориулсан сургалтын хөтөлбөртэй байна.
 - Сургалтын хөтөлбөрт эхийн сүүгээр хооллолтыг дэмжих “Арван алхам”-д хамааралтай бүх сэдвийг багтаасан байна.
 - Сургалтын хөтөлбөрийн багтаамж нь 18 цагаас багагүй, түүний 3 цагт нь дадлагын хичээл орохоор төлөвлөнө.
2. Сургалтын агуулга нь дараах асуудлуудыг хамруулсан байна. Үүнд:
 - Эхийн сүүгээр хооллолтын талаарх бодлого, хууль эрх зүйн актууд
 - Эхийн сүүгээр хэрхэн хооллох
 - Эхийн сүүгээр хооллолтын түгээмэл бэрхшээлүүд
 - Эхийн сүүгээр хооллолтын дадлууд
 - Жирэмсэн эмэгтэй, хөхүүл эхийг сонсох болон зөвлөгөө өгөх ур чадвар
 - ХДХВ-ийн халдвартай эхийн хүүхдийг хооллох арга
 - Хүүхдээ эхийн сүүгээр хооллоход эхэд дэмжлэг тусламж үзүүлэх ур чадвар
 - Хүүхдийн хооллолтын талаар мэдээлэл цуглуулах, үнэлэх ур чадвар
3. Эхчүүд болон тэдний гэр бүлийнхэнд тусгай хөтөлбөрийн дагуу сургалтыг үе шаттай явуулах, зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх ажилтныг тусгайлан бэлтгэсэн байна.

4.3 ГУРАВДУГААР АЛХАМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗААВАР:

Жирэмсэн эмэгтэйг хүүхдээ хөхүүлэхэд бэлтгэх, тэдэнд болон гэр бүлд нь эхийн сүү болон хүүхдээ хөхүүлэхийн ач тусыг ойлгуулах

1. Төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгээс бусад эрүүл мэндийн байгууллагууд жирэмсэн эмэгтэйчүүдэд зориулсан сургалтын хөтөлбөртэй байна.
2. Сургалтын хөтөлбөр нь дараах агуулгыг багтаасан байна.
 - Эхийн сүүгээр хооллохын ач тус болон хүүхдийг 6 сар хүртэл эхийн сүүгээр дагнан хооллох
 - Хөхний арчилгаа
 - Имж-эх асаргаа
 - Хүүхдийн сүүн тэжээлээр хооллох, угж болон саатуулах хөхөлт хэрэглэх эрсдэлүүд
 - “Жирэмсэн эмэгтэйн хяналтын хөтөч”-д заасан сургалтын сэдэв, эзэмшүүлсэн дадлын талаар тэмдэглэл хөтөлсөн байна.

4.4 ДӨРӨВДҮГЭЭР АЛХАМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗААВАР:

Эх, нярайд төрсний дараах эхний 90 минутад эхийн сүүгээр хооллох тусламж дэмжлэгийг үзүүлэх.

1. Төрсний дараа нярайг нэн даруй эхийн энгэрт тэврүүлнэ.
 - Хүүхэд хэвийн амьсгалж байвал жинлэх, хэмжих зэрэг тогтсон ажилбаруудыг хойшлуулна.
 - Эхийн цээж, хэвлий дээр нярайг нүцгэн тавьж, арьс арьсаар шүргэлцүүлнэ.
 - Үйлдлийн эхэлсэн, дууссан цаг хугацаа болон бусад зүйлийн талаар тэмдэглэл хөтөлнө.
 - Кесар хагалгаагаар төрсөн үед ч хүүхдийг эхийн энгэрт тэврүүлнэ.
2. Ангир уургаар амлуулна.
 - Хүүхэд өөрөө хөхөө хайж олох чадвартай байдаг тухай эхэд тайлбарлана.
 - Нярайг сайтар ажиглаж, хөхөө хайх шинж илэрсэн үед амлуулна.

4.5 ТАВДУГААР АЛХАМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗААВАР:

Эхчүүдэд хүүхдээ хөхүүлэх, саах аргыг сургасан байх ба нийтлэг тохиолддог бэрхшээлийг шийдвэрлэхэд тусламж дэмжлэг үзүүлэх.

1. Эхийн сүүгээр хооллоход тусламж дэмжлэг үзүүлнэ.
 - Эхчүүдэд хүүхдээ хэрхэн зөв байрлуулах, амлуулах талаар заана.
 - Хөхөө саах аргыг заана.
 - Эхэд саасан сүүгээ аюулгүй хадгалах талаар тайлбарлаж өгсөн байна.
 - Аяга, халбагаар хэрхэн хооллохыг хэлж өгнө.
2. Хүүхдээ хөхүүлдэггүй буюу холимог хоолтой хүүхэдтэй эхчүүдэд тусламж дэмжлэг үзүүлэх
 - Эхэд хүүхдийг эхийн сүүгээр хооллохын ач холбогдлын талаар танилцуулж, шийдвэр гаргахад нь дэмжлэг үзүүлнэ.
3. Тусгай асрамжинд байгаа эхэд хөхөө байнга саах, хүүхдээ хөхүүлэхэд нь тусламж дэмжлэг үзүүлнэ.

4.6 ЗУРГААДУГААР АЛХАМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗААВАР:

Хүүхдийн сүүн тэжээлээр хооллож буй (эх нь хүндээр өвдсөн, ХДХВ-ийн халдвартай, нас барсан г.м) хүүхэдтэй асран хамгаалагч нарт тусламж дэмжлэг үзүүлэх.

1. Хүүхдийг Зориулалтын бүтээгдэхүүнээр хооллодог нярайн талаарх мэдээллийг “Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-т тэмдэглэнэ.
2. Хүүхдийн сүүн тэжээлийг хэрхэн бэлтгэх, хадгалах талаар асран хамгаалагчид ганцаарчилсан зөвлөгөө өгнө.

4.7 ДОЛООДУГААР АЛХАМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗААВАР:

Төрсний дараа эх, хүүхдийг ямагт хамт нэг өрөөнд байлгана.

1. Төрсний дараа эх, хүүхдийг 24 цагийн турш нэг өрөөнд хамт байлгана.
2. Нярайг эхийн орон дээр хамт, эсвэл ээж нь авахад ойр байлгана.
3. Кесар хагалгаа хийлгэсэн эх хүүхдээ харах чадвартай байвал төрсний дараах мөчөөс эхлэн хүүхэдтэй нь хамт байлгана.
4. Ямар нэгэн эрүүл мэндийн шалтгаангүй бол эх, хүүхдийг ямагт хамт байлгана.

4.8 НАЙМДУГААР АЛХАМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗААВАР:

Хүүхдийг хүссэн үед нь хөхүүлэх.

1. Хүүхэд хөхөө ойр ойрхон хөхөх, хөхөлтийн үргэлжлэх хугацааг хязгаарлахгүй байх, хүүхдийг хүссэн үед нь хөхүүлэх боломж, нөхцөлийг бүрдүүлнэ.
2. Хүүхдээ өлссөн үед нь болон хөхөхийг хүссэн үед нь хөхүүлж байх зөвлөгөөг эхчүүдэд өгнө.

4.9 ЕСДҮГЭЭР АЛХАМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗААВАР:

Угж болон саатуулах хөхөлт хэрэглэхийн сөрөг үр дагаврын талаар зөвлөгөө өгөх.

1. “Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай” хуулийг дагаж мөрдөнө.
2. Угж болон саатуулах хөхөлт хэрэглэхийн сөрөг үр дагаврын талаар эхтэй ярилцаж зөвлөгөө өгнө.

4.10 АРАВДУГААР АЛХАМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗААВАР:

Төрөх эмнэлгээс гарсны дараа ч эх, хүүхдэд үргэлжлүүлэн дэмжлэг, тусалцаа үзүүлнэ.

1. Гэр бүлийн гишүүдэд хүүхдийг эхийн сүүгээр хооллохын ач холбогдлын талаар мэдлэг олгоно. Үүнд:
 - Нялх, балчир насны хүүхдэд үзүүлэх эхийн сүүгээр хооллолтын ач холбогдол
 - Хүүхдээ хөхүүлснээр эхэд үзүүлэх ач холбогдол
 - Хүүхдийг эхийн сүүгээр хооллосноор гэр бүл/нийгэмд үзүүлэх таатай нөлөө
2. Эх, хүүхэд эмнэлгээс гарсны дараа хүүхдийг эхийн сүүгээр хооллоход нь дэмжиж туслан эхчүүдтэй холбоотой байна. (төрсний дараах хяналт, гэрээр очих, утсаар ярих гэх мэт).
3. Эхчүүдийн дэмжих бүлгийг байгуулж ажиллуулах

ТАВ. “АРВАН АЛХАМ”-ЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Эрүүл мэндийн байгууллага бүр эх, нярайд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхдээ эхийн сүүгээр хооллох дэмжлэгт орчныг бүрдүүлж, эмнэлзүйн тусламж үйлчилгээндээ өөрчлөлт, шинэчлэл хийснээр бүх ээжүүд төрөхдөө шинжлэх ухааны үндэслэлтэй, нотолгоонд суурилсан өөрт хэрэгцээтэй тусламж үйлчилгээг цаг хугацаанд нь авах боломжийг бүрдүүлэх үүрэгтэй.

Эхийн сүүгээр хооллолтыг хамгаалах, дэмжих, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахад эрүүл мэндийн тогтолцоо чухал бөгөөд ДЭМБ-аас эрүүл мэндийн тогтолцооны хүрээг дараахь бүрэлдэхүүн хэсгээр тодорхойлсон байдаг. Үүнд:

- эмнэлгийн тусламж, үйлчилгээ
- эрүүл мэндийн салбарын ажиллах хүчин
- эрүүл мэндийн мэдээллийн тогтолцоо
- нэн шаардлагатай эмийн хүртээмжтэй байдал
- санхүүжилт
- манлайлал/засаглалын асуудлууд багтдаг.

Эдгээр асуудлууд нь **“Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих”** бодлогыг үндэсний түвшинд амжилттай хэрэгжүүлэхэд шууд хамааралтай ба дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд.

1. Хүүхдийг эхийн сүүгээр хооллох бодлогыг хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх үндэсний байгууллагын чадавхийг бэхжүүлнэ.
2. Үндэсний хэмжээнд мөрдөх холбогдох бодлогын баримт бичгүүд, түүнчлэн эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх стандарт, магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтэд эхийн сүүгээр хооллолтын “Арван алхам”-ыг тусгаж уялдуулсан байна.
3. Эхийн сүүгээр хооллолтын “Арван алхам”-ыг хэрэгжүүлж буй байгууллагын удирдах ажилтнууд болон мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлнэ.
4. Эхийн сүүгээр хооллолтын “Арван алхам”-ын хэрэгжилтийн байдалд хөндлөнгийн үнэлгээ тогтмол хийх тогтолцоо бүрдүүлнэ.
5. Эхийн сүүгээр хооллолтын “Арван алхам”-ыг амжилттай хэрэгжүүлж буй нэгж, тасаг, байгууллага, хамт олон, хувь хүнийг урамшуулан дэмжих, сайшаах, олон нийтэд алдаршуулах гэх мэт арга хэмжээг зохион байгуулах ба хэрэгжилт хангалтгүй тохиолдолд хариуцлага тооцох тогтолцоог бүрдүүлнэ.
6. Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих “Арван алхам”-ыг шинээр нэвтрүүлэх зорилгоор шинэчлэл өөрчлөлт хийж буй байгууллагуудад техникийн дэмжлэг туслалцаа үзүүлнэ.
7. Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих “Арван алхам”-ыг зорилтот бүлгүүдэд мэдээлж, сурталчилна.
8. Идэвхитэй, үр дүнтэй хэрэгжүүлж байгаа байгууллага, хамт олонд техник, санхүүгийн дэмжлэг туслалцаа үзүүлэх, хөрөнгийн эх үүсвэрийг тодорхойлж, хуваарилах ажлыг зохион байгуулна.

ЗУРГАА. ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ ХИЙХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ БА АРГАЧЛАЛ

Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих “Арван алхам”-ыг хэрэгжүүлж байгаа байгууллагууд үйл ажиллагаандаа дотоодын болон хөндлөнгийн хяналт үнэлгээг хийнэ. Үүнд:

1. Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих “Арван алхам” -ыг хэрэгжүүлж байгаа байгууллага өөрөө өөрийгөө дүгнэнэ. (*Хавсралт 1*). Тухайн байгууллага нь эхийн сүүгээр хооллолтыг дэмжих “Арван алхам”-ыг биелүүлж чадаж байгаа эсэхдээ дүгнэлт өгнө. Хяналт үнэлгээний асуумж нь “Арван алхам”-ын үндсэн шалгуур үзүүлтүүдийг хамруулах ба ДЭМБ-аас гаргасан зөвлөмж, заавар, удирдамжинд үндэслэнэ.
2. Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны эрх (лиценз) авах болон сунгуулахдаа эхийн сүүгээр хооллолтыг дэмжих “Арван алхам”-ыг өөрийн

байгууллагын үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байдалд үнэлгээ хийж, өөрөө өөрийгөө дүгнэх асуулгад хангалттай үнэлгээ авсан бол үнэлгээний дүгнэлтийг магадлан итгэмжлэлд орох хүсэлтийн хамт холбогдох байгууллагад ирүүлнэ. Тухайн байгууллага нь өөрөө өөрийгөө үнэлсэн үнэлгээгээр $\geq 80\%$ авсан тохиолдолд үндэсний мэргэжлийн шинжээчид хөндлөнгийн үнэлгээ хийнэ. (Хавсралт 2)

3. Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих “ Арван алхам” -ыг үнэлэх аргачлал
Эхийн сүүгээр хооллолттой холбоотой мэдээлэл цуглуулна.
 - Эхийн сүүгээр хооллолтын байдал: Тухайн жилд төрсөн хүүхэд, үүнээс эхийн сүүгээр хооллосон болон сүүн тэжээлээр хооллосон хүүхдийн тоо, мэдээ, тайланд үнэлгээ өгнө.
 - Ангир уургаар амалсан, амлаагүй, дагнан эхийн сүүгээр хооллож байгаа, 1, 2 нас хүртлээ эхийн сүүгээр хооллож байгаа хүүхдийн мэдээ, тоо, тайланд үнэлгээ өгнө.
4. Эрүүл мэндийн байгууллагын ажилтныг сургалтанд хамруулсан байдалд үнэлгээ өгнө. (Хавсралт.3)
 - Сургалтын тайлан
 - Сургалтын тайлангийн хураангуй
 - Сургалтыг хянах хуудас
5. Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд ажиглалт хийж, (Хавсралт 4) санамсаргүй түүврийн аргаар сонгосон холбогдох хүмүүстэй шинжээчид ганцаарчилсан ярилцлагыг доорх асуумжуудыг ашиглан хийнэ. Үүнд:
 - Эрүүл мэндийн ажилтантай хийх ярилцлага (Хавсралт 5)
 - Эрүүл мэндийн бус ажилтантай хийх ярилцлага (Хавсралт 6)
 - Хөхүүл эхтэй хийх ярилцлага (Хавсралт 7)
 - Асаргаа халамж шаардсан хүүхдийн эхтэй хийх ярилцлага (Хавсралт 8)
 - Жирэмсэн эмэгтэйтэй хийх ярилцлага (Хавсралт 9)
6. Шинжээчид ганцаарчилсан ярилцлага хийсний дараа бүх асуумжуудыг нэгтгэн дүгнэх хүснэгтийг бөглөнө. (Хавсралт.10)

Эрүүл мэндийн байгууллага өөрөө өөрийнхөө үйл ажиллагааг үнэлэх асуумж

Эрүүл мэндийн байгууллага нь хэрэгжүүлсэн үйл ажиллагаагаа дараах таван бүлэг асуултаар үнэлнэ. Үүнд:

1. Удирдлага, зохион байгуулалт
2. Ажилчдыг сургалтанд хамруулсан байдал
3. Үйл ажиллагааны хэрэгжилтийн байдал
4. Жирэмсэн, хөхүүл эхчүүдийг сургалтанд хамруулсан байдал
5. Эзэмшвэл зохих дадлууд

Үнэлэх шалгуур үзүүлэлт: Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих “Арван алхам”-ыг хэрхэн хэрэгжүүлсэн байдалд үнэлгээ өгөхдөө дараах 5 ангилалыг баримтлан оноог өгнө. Хэрэв бүх үзүүлэлт нь $\geq 80\%$ байвал “Арван алхам”-ыг хангалттай хэрэгжүүлсэн байна үзнэ.

0 - бүх шалгуур үзүүлтийн 30% ба түүнээс доош “ТИЙМ” гэж хариулсан бол

1- нэг шалгуур үзүүлэлтэнд 30% бусад шалгуур үзүүлэлтээ 30% ба түүнээс доош “ТИЙМ” гэж хариулсан бол

2- бүх шалгуурын үзүүлэлтэнд 60% -иас багагүй “ТИЙМ” гэж хариулсан бол

3- нэг шалгуур үзүүлэлтэнд 60% бусад шалгуур үзүүлэлтээ 80% ба түүнээс доош “ТИЙМ” гэж хариулсан бол

4- бүх шалгуурын үзүүлэлтэнд 80% ба түүнээс доош “ТИЙМ” гэж хариулсан бол

1. Удирдлага, зохион байгуулалт

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Үнэлэх арга	Тэмдэглэл (±)
Зохион байгуулалт	Эрүүл мэндийн байгууллага нь эхийн сүүгээр хооллолтыг дэмжсэн өрөө, тасалгаатай байна.	Үйл ажиллагаа болон өрөө, тасалгааг үзнэ.	
Эхийн сүүгээр хооллох бодлогын хэрэгжилтийн байдалд дотоод үнэлгээ хийсэн байх. (алхам “1 C”)	Арван алхамыг тусгасан бодлоготой байна. “Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хууль”-ийн хэрэгжилт, ажилтнуудын ур чадвар, дадлыг үнэлсэн байна.	Бичиг баримтыг үзнэ.	
	Зургаан сар тутамд хэрэгжилтийн үр дүнг үнэлсэн тайлан байх ба тухайн үеийн асуудлыг яаж шийдвэрлэсэн талаараа тэмдэглэл хөтөлсөн байна.	Хурал уулзалтаас гарсан санал, түүнийг хэрэгжүүлэх талаар гарсан төлөвлөгөө, тэмдэглэл, тайланг үзнэ.	

<p>“Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хууль”-ийн зүйл, заалтыг дагаж мөрдөнө. (алхам “1 А”)</p>	<p>Хүүхдийн сүүн тэжээл, хооллох хэрэгсэл (угж, хөхөлт) зэргийг худалдаалах, ханган нийлүүлэх болон үнийн хямдрал, хөнгөлөлт, тусгай урамшуулал аваагүй байна.</p>	<p>Эрүүл мэндийн байгууллага доторх худалдааны цэгийн үйл ажилгааны баримтжуулалтыг үзнэ.</p>	
	<p>Эрүүл мэндийн байгууллагад хооллох хэрэгслийн сав баглаа боодол, шошгод үйлдвэрлэгчийн лого, зураг, дүрс зар сурталчилгааг байрлуулахгүй.</p>	<p>Ажиглалтаар дүгнэнэ.</p>	
	<p>Эрүүл мэндийн ажилтан нь жирэмсэн болон хөхүүл эхэд нялх, балчир хүүхдийг хооллоход зориулсан бүтээгдэхүүнийг тараах, шууд ба шууд бусаар санал болгож болохгүй.</p> <p>Жирэмсэн, хөхүүл эх ба тэдний гэр бүлийнхэнд хүүхдийн сүүн тэжээл, хооллох хэрэгсэл зэргийг санал болгох, бэлэглэх, тусгай урамшуулал өгөхийг хориглоно.</p>	<p>Зохион байгуулсан арга хэмжээний тайлан болон үйл ажилгааны баримт, бичгийг үзнэ.</p>	
	<p>Эрүүл мэндийн байгууллага нь үйлдвэрлэл эрхлэгчдээс хүүхдийн сүүн тэжээл, хооллох хэрэгсэл, ном, сэтгүүл, эмнэлгийн багаж хэрэгсэл, үнэгүй сургалт, мөнгө, бэлэг, тусгай урамшуулал зэргийг авч болохгүй.</p>	<p>Зохион байгуулсан арга хэмжээний тайлан болон үйл ажиллагааны баримт, бичгийг үзнэ.</p> <p>Ажиглалтаар дүгнэнэ.</p>	
<p>Эхийн сүүгээр хооллолтыг дэмжсэн бодлогын бичиг баримтыг эмч, эмнэлгийн ажилтнууд болон эцэг/эхчүүдэд танилцуулсан байна (алхам “1 В”)</p>	<p>“ Нялх,балчир хүүхдийн хүнсний тухай хууль”-ийн хэрэгжилт, ажилтнуудын ур чадвар, дадлыг үнэлсэн байна.Удирдамжид эхийн сүүгээр хооллохгүй байгаа болон холимог хоолтой хүүхэдтэй эхчүүдэд асуудлаа шийдэхэд нь тусламж дэмжлэг үзүүлэх талаар тусгасан байна.</p>	<p>Бичиг баримтыг үзнэ</p> <p>Үнэлгээний тайланг үзнэ.</p>	
	<p>Эхийн сүүгээр хооллолтыг дэмжсэн бодлогыг жирэмсэн, хөхүүл эх болон тэдний гэр</p>	<p>Ажиглалтаар</p>	

	бүлийнхэнд харагдахуйц газар байрлуулсан байна.	дүгнэнэ.	
Эхийн сүүгээр хооллолтыг тууштай дэмжсэн бодлогын бичиг баримттай байна.			
Жирэмсэн эх бүрийг хүүхдээ хөхүүлэхэд нь бэлдүүлэх, тэдэнд эхийн сүүний болон хүүхдээ хөхүүлэхийн ач тусыг ойлгуулсан байна. (алхам “З”)	Удирдамжид жирэмсэн эхэд үзүүлэх тусламж үйлчилгээг оруулсан байна.	Бичиг баримтыг үзнэ.	
	Удирдамжид дараах асуудлуудыг тусгасан байна. <ul style="list-style-type: none"> - Эхийн сүүгээр хооллохын ач тус - Нялхсын сүүн тэжээл ба сүүн тэжээлээр хооллохын эрсдэл - 6 сар хүртэл эхийн сүүгээр дагнан хооллох - Нэмэгдэл хоол - Имж асаргаа - 24 цаг хамт байлгах - Хөхүүлэх дараалал - Хүүхдийг хүссэн үед нь хөхүүлэх - Хөхүүлэх байрлал - Төрөхийн өмнө тайвшруулах, өвчин намдаах эм хэрэглэх шийдвэр гаргах үед тэдэнд хүүхдээ хөхүүлэх зайлшгүй шаардлагатайг ойлгуулахад чиглэсэн байна. 	Удирдамжид 12 сэдвээс (багадаа) 9 нь орсон эсэхийг үзнэ.	
	Гарын авлага, зурагт хуудас, видео хичээл нь үндсэн мэдээлэлтэй зөрчилдөхгүй байна.	Бичиг баримт болон ажиглалтаар дүгнэнэ.	
	Удирдамжид төрсний дараа эхэд үзүүлэх тусламж үйлчилгээг оруулсан байна.	Бичиг баримтыг үзнэ	

<p>Эхчүүдэд хүүхдээ хөхүүлэх, саах аргыг сургасан байх ба нийтлэг тохиолддог бэрхшээлийг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ. (алхам 5)</p>	<p>Удирдамжид дараах асуудлуудыг тусгасан байна.</p> <ul style="list-style-type: none"> - Эхийн сүүгээр хооллох зарчим, арга барил (байрлал) - Эхийн сүүний нөөц, хангалттай сүүтэй байх - Хөхөнд сүү оруулах - Хүүхдийг хүссэн үед нь хөхүүлэх - Хөхөө арчилах - Хөх өвчилсөн тохиолдолд ямар арга хэмжээ авах - Хөхний толгой хагарахаас сэргийлэх - Хүүхдэд угж болон саатуулах хөхөлт хэрэглэх эрсдэл 		
<p>Хүүхдийг эхийн сүүгээр хооллохгүй байгаа эхчүүдэд асуудлаа шийдэхэд нь тусламж дэмжлэг үзүүлнэ (алхам 6)</p>	<p>Удирдамжид нярайн сүүн тэжээл болон бусад хооллолтын талаар оруулсан байна.</p>	<p>Бичиг баримтыг үзнэ.</p>	
	<p>Удирдамжид дараах зүйлийг оруулна:</p> <ul style="list-style-type: none"> - Нярайн сүүн тэжээлийн сонголтуудын талаарх мэдээлэл. - Эхэд асуудлаа шийдэхэд нь тусламж, дэмжлэг үзүүлэх - Сүүн тэжээлийг хэрхэн бэлтгэх - Хэрэглэсэн угж, саатуулах хөхөлтийг ариутгах, угаах - Хүүхдээ хүссэн үед хооллох 	<p>Бичиг баримтыг үзнэ.</p>	
	<p>Удирдамжид төрөх эмнэлгээс гарахын өмнөх зөвлөгөө, тусламж өгөх талаар оруулсан байна.</p>	<p>Бичиг баримтыг үзнэ.</p>	
	<p>Удирдамжид дараах асуудлуудыг тусгасан байна.</p> <ul style="list-style-type: none"> - Эхийн сүүгээр 		

Төрөх эмнэлгээс гарсны дараа эх, хүүхдэд үргэлжлүүлэн тусламж дэмжлэг үзүүлнэ. (алхам 10)	<ul style="list-style-type: none"> - үргэлжлүүлэн хооллох - Эхийн сүүний нөөц, хангалттай сүүтэй байх - Хүүхэд хөхөх гэж байгааг мэдрэх, хүссэн үед нь хөхүүлж байх - Эхэд бие махбодь болон сэтгэлзүйн туслалцаа үзүүлэх - Төрөх эмнэлгээс гарсны дараа хаана хандах талаар зөвлөх 	Бичиг баримтыг үзнэ.	
	Эхийн сүүгээр хооллох, эхээс эхэд үзүүлэх зөвлөгөө тусламж, дэмжлэг үзүүлдэг сайн дурын идэвхитнүүдтэй хамтран ажиллана.	Зохион байгуулсан арга хэмжээний тайлан болон үйл ажиллагааны баримт, бичгийг үзнэ	
Ажлын байранд эхийн сүүгээр хооллолтыг дэмжих	Ажиллаж байгаа эхчүүдэд зориулж хүүхдээ хөхүүлэх орчинг бүрдүүлж, дэмжлэг үзүүлж ажилласан байна.	Хөхүүл хүүхэдтэй ажлаа хийж байгаа эхчүүдтэй ярилцах ба МУ-ын хөдөлмөрийн хуулийн 102, 103, 107 дугаар зүйлийн болон бусад холбогдох эрхзүйн бичиг баримтуудын хэрэгжилтийг үнэлнэ.	

2. Ажилчдыг сургалтанд хамруулсан байдал

Зорилго: ЭМБ ажилчиддаа эхийн сүүгээр хооллолтыг дэмжих бодлого, хэрэгжилтийн талаар танилцуулна. Эхийн сүүгээр хооллохын ач холбогдол, жирэмсэн, хөхүүл эхэд хэрхэн тусламж, үйлчилгээ үзүүлж ажиллах нь тэдний үүрэг гэдгийг тайлбарлана.

Зорилт: ЭМБ-ын ажилчид эхийн сүүгээр хооллолтыг дэмжихэд чиглэсэн сургалтанд тасралтгүй хамрагдсан байна.

Үнэлэх шалгуур үзүүлэлт: Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих “Арван алхам”-ыг хэрхэн хэрэгжүүлсэн байдалд үнэлгээ өгөхдөө дараах 5 ангилалыг баримтлан оноог өгнө. Хэрэв бүх үзүүлэлт нь $\geq 80\%$ байвал “Арван алхам”-ыг хангалттай хэрэгжүүлсэн байна үзнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Үнэлэх арга	Тэмдэглэл (±)
	Ажилчид нь эхийн сүүгээр хооллолтыг дэмжсэн бодлогыг танилцуулах	Сургалтын тайланг үзнэ. Сургалтанд хамрагдсан	

Ажилчид нярай хүүхдийг хооллох хангалттай мэдлэг, ур чадвартай, дадалтай байна.(алхам 2)	сургалтанд хамрагдсан байна.	ажилчдын хувь 80%-иас багагүй байна.	
	Сургалтын хөтөлбөр, сургалтанд хамрагдсан ажилчдын бүртгэлтэй байна.	Бичиг, баримтыг үзнэ.	
	Жирэмсэн,хөхүүл эх болон нярай хүүхдийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа ЭМ-ийн ажилтан нь эхийн сүүгээр хооллолтын талаар сүүлийн 2 жилд сургалтанд хамрагдсан байна.	Сургалтын тайланг үзнэ. Сургалтанд хамрагдсан ЭМ-ийн ажилчдын хувь нь 80%-иас багагүй байна.	
	Жирэмсэн,хөхүүл эх болон нярай хүүхдийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа ЭМ-ийн ажилтан нь эхийн сүүгээр хооллолтын талаар сүүлийн 2 жилд дадлагын үнэлгээнд хамрагдсан байна.	Сургалтын тайланг үзнэ. Үнэлгээнд хамрагдсан ЭМ-ийн ажилчдын хувь нь 80%-иас багагүй байна	
	ЭМ -ийн ажилтан нь жирэмсэн, хөхүүл эхийн тусламж үйлчилгээ болон нялх, бага насны хүүхдийг эхийн сүүгээр хооллох талаар мэдлэг шалгах асуултанд хариулна.	Хариултыг үзнэ. Дөрвөн асуултын 3 нь зөв байх ба хариултын хувь 80%-иас багагүй байна.	
	Сайн дурын идэвхитнүүд нь хөхүүл эх болон нярай хүүхдийн тусламж үйлчилгээ, эхийн сүүгээр хооллолтын талаар өөрсдийн мэргэжил ур чадвараа дээшлүүлсэн байна.	Сургалтын тайланг үзнэ. Сургалтанд хамрагдсан сайн дурын идэвхтэний хувь нь 80%-иас багагүй байна.	
	Сайн дурын идэвхитнүүд нь эхийн сүүгээр хооллохын ач холбогдлыг тайлбарлах чадвартай эсэх, эхэд хүүхдээ хөхүүлэхэд тусламж үзүүлэх дадалтай эсэх, тэдний зөвлөгөө тусламжаар эхчүүд хүүхдээ хэрхэн зөв хөхүүлж байгааг үнэлнэ.	Сайн дурын идэвхтэнтэй ярилцлага хийнэ. 3 чадварын үзүүлэлт нь 80% - иас багагүй байна	

Сургалтанд хамрагдсан ЭМБ-ын ажилчдын мэдлэг,ур чадварыг дараах байдлаар үнэлнэ.

1. Эхийг сонсох болон сургах чадвартай эсэх
2. Эхэд хүүхдээ хөхүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх ур чадвартаа итгэлтэй байдал
3. Жирэмсэн эмэгтэйтэй эхийн сүүгээр хооллохын ач холбогдлын талаар ярилцах, дадал эзэмшүүлэх чадвар
4. Төрсний дараа 1 цагийн дотор хүүхдийг ангир уургаар хөхүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх
5. Эхийг хүүхдээ зөв байрлалтай хөхүүлж байгааг үнэлэх чадвартай байх
6. Эх хүүхдээ хөхүүлэх талаар зааж, туслах
7. Эхэд хүүхдээ үр дүнтэй хооллох талаар тайлбар өгөх чадвартай байх
8. Хүүхэд сайн хөхөж байгааг дүгнэх чадвар
9. Эхэд хүүхдээ хүссэн үед нь цадтал хөхүүлэхийг ойлгуулах
10. Эхэд сүүний гарцаа хэрхэн үнэлэх талаар ойлгуулах
11. Эхэд аягаар хэрхэн хооллох талаар заах
12. Хөхний сүү хангалтгүй эхэд зөвлөх чадвар
13. Хүүхэдтэйгээ харьцах талаар зөвлөгөө өгөх
14. Хөхөө хөхөхгүй байгаа хүүхдийн асуудлыг шийдвэрлэхэд туслах
15. Доорхи шалтгаантай эх хүүхдээ хэрхэн хөхүүлэх талаар зөвлөгөө өгөх
 - а. Шигдсэн болон том хөхний толгойтой
 - в. Хөхнөөс цус гарж байгаа
 - с. Хөхний толгой хагарсан
 - д. Хөхний үрэвсэлтэй
16. Бага жинтэй болон өвчтэй нярайг хөхүүлэхэд эхэд туслах
17. Эхийн сүүгээр хооллохгүй (холимог хооллолтой) байгаа эхэд асуудлаа шийдэхэд нь зөвлөх чадвартай байх
18. Эхийн сүүгээрээ хооллохгүй (холимог хооллолттой) байгаа эх хүүхдээ эрүүл, аюулгүй сүүн тэжээл сонгож хэрэглэх талаар мэдлэгтэй эсэхийг нь үнэлэх
19. Эхийн өвчлөл,эрүүл мэндийн талаар зөвлөгөө өгөх
20. Яагаад эхэд тусламж ,үнэлгээ хэрэгтэй болдог талаар ярилцах
21. Холбогдох бодлого,хууль эрх зүйн талаар мэдлэгтэй байх

3. Үйл ажиллагааны хэрэгжилтийн байдал

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Үнэлэх арга	Тэмдэглэл (±)
Ганцаарчилсан зөвлөгөө өгөх өрөөтэй байна.	Жирэмсэн, хөхүүл эх ба нялх, бага насны хүүхдэд зориулсан өрөөтэй байна.	Ажиглалтаар үнэлнэ.	
Эхчүүдэд хүүхдээ хөхүүлэх,саах аргыг сургасан байх ба нийтлэг тохиолддог бэрхшээлийг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ. (алхам 5)	Сүүгээ саах, хадгалах зориулалтын ариутгасан саваар үнэгүй хангана.	Ажиглалт болон тайланг үзнэ.	
Хүүхдээ эхийн сүүгээр хооллохгүй эхчүүдэд асуудлаа шийдэхэд нь тусламж дэмжлэг үзүүлнэ. (алхам 6)	Хүүхдээ эхийн сүүгээр хооллохгүй байгаа эх хүүхдийнхээ сүүн тэжээлийг бэлтгэхэд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангасан байна.	Ажиглалтаар үнэлнэ.	

	Угж,хөхөлт ба хүүхэд хооллох хэрэгслийг угаах, ариутгах, хадгалах гэх мэт аюулгүй байдлыг хангасан байна.	Ажиглалтаар үнэлнэ.	
	Лаазтай сүүн тэжээл, угж зэргийг ил харагдах газар байрлуулахгүй.	Ажиглалтаар үнэлнэ.	
Ажлын байранд эхийн сүүгээр хооллохыг дэмжих	Хөхүүл эх сүүгээ саах, хадгалах зориулалтын өрөө, хөргөгчтэй байна.	Ажиглалтаар үнэлнэ.	

4.Жирэмсэн, хөхүүл эхчүүдийг сургалтанд хамруулсан байдал

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Үнэлэх арга	Тэмдэглэл (±)
Жирэмсэн эх бүрийг хүүхдээ хөхүүлэхэд нь бэлтгэх,тэдэнд эхийн сүүний болон хүүхдээ хөхүүлэхийн ач тусыг ойлгуулсан байна.(алхам 3)	Жирэмсэн эхэд төрөхийн өмнөх эхийн сүүгээр хооллолтын талаар мэдээлэл өгч ярилцсан байна.	Төрөхийн өмнөх үйлчилгээ үзүүлдэг алба, тасаг нь жирэмсэн эхчүүдэд зөвлөгөө өгсөн байна. (80%-иас багагүй хувийг хамруулах) Зөвлөгөө өгсөн тэмдэглэлийг үзнэ.	
	Төрөхийн өмнөх сургалтыг үр дүнтэй сайн хийсэн байна.	Жирэмсэн эх нь хамгийн багадаа хоёр сэдвийг хангалттай мэдэж байвал 80% гэж үзнэ.	
Эхчүүдэд хүүхдээ хөхүүлэх,саах аргыг сургасан байх ба нийтлэг тохиолддог бэрхшээлийг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ.(алхам 5)	Хөхүүл эх нь өөрт тохирсон байрлалаар сууж хүүхдээ зөв хөхүүлнэ.	Хөхүүл эх нь хамгийн багадаа гурван сэдвийг хангалттай мэдэж байвал 80% гэж үзнэ.	
	Хөхүүл эх нь хөхөнд сүү оруулах, хөх өвчилсөн тохиолдолд ямар арга хэмжээ авах талаар,хөхний толгой хагарахаас сэргийлэх зэргийг заалгаж мэдсэн байна.	Хөхүүл эх нь хамгийн багадаа хоёр сэдвийг хангалттай мэдэж байвал 80% гэж үзнэ.	
	Хөхүүл эх нь өөрийн сүүний гарцаа хэрхэн нэмэгдүүлэх талаар мэдлэгтэй байна.	Хөхүүл эхийн сүүний гарцыг хэрхэн нэмэгдүүлэх	

		талаарх мэдлэг нь 80% -иас багагүй байна.	
	Эх, хүүхэд тусдаа байх үед хөхүүл эх нь хөхөө сааж аюулгүй хадгалах талаар мэддэг байна. (саалтуур хэрэглэх)	Төрсний дараа хүүхдээсээ тусдаа байгаа эхийн хөхөө сааж, аюулгүй хадгалах талаарх мэдлэг 80% -иас багагүй байна.	
	Эхийн сүүгээр хооллохгүй байгаа болон холимог хооллолттой эхчүүд асуудлаа шийдэх талаар тусламж дэмжлэг, мэдээлэл авсан байна.	Эхийн сүүгээр хооллохгүй байгаа болон холимог хооллолттой эхчүүдэд асуудлаа шийдэх талаарх мэдээлэл өгсөн байдал 80% -иас багагүй байна.	
Хүүхдээ эхийн сүүгээр хооллохгүй байгаа эхчүүдэд асуудлаа шийдэхэд нь тусламж дэмжлэг үзүүлнэ. (алхам 6)	Эх нь хүүхдээ яаж хооллох, нярайн сүүн тэжээлийг хэрхэн бэлтгэх, хадгалах талаар ганцаарчилсан зөвлөгөөг авсан байна.	Ганцаарчилсан зөвлөгөөг авсан эхчүүдийн хувь 80% -иас багагүй байна.	
	Хүүхдийн хооллолтыг хязгаарлах төлөвлөгөө байж болохгүй.	Төрөхийн өмнөх тусламж үйлчилгээ үзүүлэх албаны тайланд хүүхдийн хооллолтыг хязгаарлах талаар мэдээлэл оруулж болохгүй. Хүүхдийг хүссэн үед нь хооллож байх талаар зөвлөгөө мэдээлэл авсан эхчүүд 80% -иас багагүй байна	
Хүүхдийг хүссэн үед нь хооллож байх.(алхам 8)	Хүүхэд хөхөө хөхөх гэж байгаа шинж тэмдгийг мэдрэх, хүүхэдтэйгээ аль болох дотно байж гүйцэт хөхүүлэх.	Төрсөн эхтэй ярилцана. Эхийн мэдлэг 80%-иас багагүй байна	
	Эх нь хүүхэд хооллох бусад аргын талаар мэдлэгтэй байна.(аяга, халбага, угж)	Төрсөн эхтэй ярилцана. Эхийн мэдлэг 80%-	

		иас багагүй байна.	
Угж, саатуулах хөхөлт хэрэглэхийн сөрөг үр дагаврын талаар мэдлэгтэй байна.(алхам 9)	Угж болон саатуулах хөхөлт хэрэглэхийн сөрөг үр дагаврын талаар мэдлэгтэй байна.	Төрсөн эхтэй ярилцана. Эхийн мэдлэг 80%-иас багагүй байна.	
	Угж болон саатуулах хөхөлт хэрэглэхийн сөрөг үр дагаврын талаар ярилцаж зөвлөгөө өгсөн байна.	Анхан төрсөн эхчүүдтэй ярилцана.	
Төрөх эмнэлгээс гарсны дараа эх, хүүхдэд үргэлжлүүлэн тусламж, дэмжлэг үзүүлнэ. (алхам 10)	Төрөх эмнэлгээс гарсны дараа эх, хүүхдэд үргэлжлүүлэн тусламж дэмжлэг үзүүлэх өрхийн эмнэлгийн талаар мэдээлэл өгсөн байна.	Төрсөн эхтэй ярилцана. Эхийн мэдлэг 80%-иас багагүй байна.	

5.Эзэмшвэл зохих дадлууд

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Үнэлэх арга	Тэмдэглэл (±)
Төрсний дараа эх,нярай хоёрыг нэн даруй арьс, арьсаар нь шүргэлцүүлнэ. (алхам 4)	Төрсний дараа эх,нярайг арьс, арьсаар нь шүргэлцүүлсэн (шууд эсвэл 5 минутанд), үргэлжлэх хугацаа нь 1 цаг эсвэл түүнээс дээш байлгасан эсэх (арьс, арьсаар шүргэлцүүлээгүй) талаар тэмдэглэл хөтөлсөн байна.	Төрсөн эхтэй ярилцана. Имж асаргаа 80%-иас багагүй байна. Ажиглалт хийнэ.	
	Кесар (ерөнхий мэдээ алдуулалт) хагалгаагаар төрсөн үед ч арьс, арьсаар нь нэн даруй шүргэлцүүлнэ.	Тайланг үзнэ мөн ажиглалт хийнэ.	
	Төрсөн эхэд хүүхэд өөрөө хөхөө хайж олох чадвартай байдаг талаар сайн тайлварласан байна. Хүүхэд хөхөө хөхтөл эх баригч эхэд тусламж, дэмжлэг үзүүлж ярилцаж урам өгнө. (эх баригч нярайг ажиглаж аль болох өөрөө хөхөө олж хөхтөл хүлээнэ)	Төрсөн эхтэй ярилцана: өөрөө хөхөө хайж хөхсөн нярайн хувь 80%-иас багагүй байна. Тайланг үзнэ мөн ажиглалт хийнэ.	
Эхчүүдэд хүүхдээ хөхүүлэх,саах аргыг сургасан	Жингийн илүүдэлтэй эх, кесар хагалгаагаар төрсөн	Төрөхийн өмнөх тусламж	

байх ба нийтлэг тохиолддог бэрхшээлийг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ.(алхам 5)	эх, хүүхэд өвчтэй, төрөлхийн гажигтай, хөхний сүүний гарц муу зэрэг шалтгаантай тохиолдолд нэмэлт тусламж үйлчилгээг үзүүлнэ.	үйлчилгээний бичиг баримтыг үзнэ.	
Хүүхдээ эхийн сүүгээр хооллохгүй эхчүүдэд асуудлаа шийдэхэд нь тусламж дэмжлэг үзүүлнэ. (алхам 6)	Нярайг заавал эхийн сүүгээр дагнан хооллоно. Эхийн сүүний гарц муу болон бусад шалтгаантай бол өөр эхийн сүүг санал болгоно (сүүний банк)	Төрөх эмнэлэг, тасагт байх хугацаандаа эхийн сүүгээр дагнан хооллолсон нярайн хувь 80% - иас багагүй байна	
	Нэмэлт тэжээл авсан нярайн талаар эмнэлгийн тайланд бичсэн байна	Бичиг баримтыг үзнэ.	
	Хүндрэлтэй төрсөн нярайд 1-2 цагийн дотор ангир уургаар амлуулахад нь тусламж, дэмжлэг үзүүлсэн байна.	Төрсөн ээжтэй ярилцана. 1-2 цагийн дотор хөхөө хөхөд нь тусламж, дэмжлэг үзүүлсэн хувь 80%-иас багагүй байна.	
Эх хүүхдийг ямагт хамтад нь (24 цаг) нэг өрөөнд байлгана. (алхам 7)	Эх, хүүхдийг эмнэлгээс гартал ямагт хамт нэг өрөөнд байлгана. Хэрэв хамт байлгах боломжгүй байсан бол шалтгааныг нь заавал тэмдэглэсэн байна.	Төрсөн эхтэй ярилцана. Ажиглалтаар үнэлнэ. Эх хүүхдийг хамтад нь байлгасан тайлан 80% -тай байна. Тусад нь байлгасан тэмдэглэл байгаа эсэхийг үзнэ.	
Эмнэлгийн ажилчид нь угж , саатуулах хөхөлт хэрэглэхийн сөрөг үр дагаврын талаар мэдлэгтэй байна .(алхам 9)	Нялхсын сүүн тэжээл өгөхдөө ямар нэгэн хооллох хэрэгсэл ашигласан бол энэ талаар тэмдэглэсэн байна (аяга, халбага, угж гэх мэт) Эхтэй ярилцаж шийдээгүй тохиолдолд сүүн тэжээл өгөхгүй, мөн угж, саатуулах хөхөлт хэрэглэхгүй.	Бичиг баримтыг үзнэ. Нялхсын сүүн тэжээл өгөхдөө эхтэй ярилцаж шийвэрлэсэн байдал 80% -иас багагүй байна.	

Эрүүл мэндийн байгууллагыг үнэлэх шинжээчдийн асуумж

Эрүүл мэндийн байгууллагын хэрэгжүүлсэн үйл ажиллагааг дараах таван бүлэг асуултаар үнэлнэ. Үүнд:

1. Удирдлага, зохион байгуулалт
2. Ажилчдыг сургалтанд хамруулсан байдал
3. Үйл ажиллагааны хэрэгжилтийн байдал
4. Жирэмсэн, хөхүүл эхчүүдийг сургалтанд хамруулсан байдал
5. Эзэмшвэл зохих дадлууд

Ерөнхий зарчим

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Үнэлэх арга	Тэмдэглэл (±)
Эх, нярайд тусламж үйлчилгээг эрт үзүүлнэ.	Төрсний дараа эх,нярайг арьс арьсаар нь шүргэлцүүлэхдээ тэр дариудаа юу ? эсвэл 5 минутын дотор уу? үргэжилсэн хугацаа нь нэг цаг уу? эсвэл түүнээс их үү? гэдэгт хувиар үнэлгээ өгнө. Үзүүлэлт нь 80%-иас багагүй байх	Тайланг үзнэ. Төрсөн эхтэй ярилцана.(3-4 эх)	
Эмнэлэгт байх хугацаандаа эхийн сүүгээр дагнан хооллосон байна.	Эмнэлэгт байх хугацаандаа эхийн сүүгээр дагнан хооллосон нярайн хувийг гаргах (Эхийн өөрийн сүү юу ? эсвэл Донор эхийн сүү юу?) Үзүүлэлт нь 80%-иас багагүй байх	Эмнэлгийн байгууллагын тайланг үзнэ. Төрсөн ээжтэй ярилцана.(3-4 эх)	

1. Удирдлага, зохион байгуулалт

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Үнэлэх арга	Тэмдэглэл (±)
Хүүхдэд ээлтэй эмнэлгийн дадал болон ур чадварыг үнэлдэг тогтолцоог бүрдүүлсэн байна.	Удирдамжид арван алхамын шалгуурыг тусгасан эсэх “ Нялх,балчир хүүхдийн хүнсний тухай хууль”-ийн хэрэгжилт, ажилтнуудын ур чадвар, дадлыг үнэлсэн байна.	Бичиг баримтыг үзнэ. Үнэлгээний тайланг үзнэ.	
